

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ОНГИ-УС СУВАГ ОНӨААТҮГ-ЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

АРВАЙХЭЭР

2022 ОН

БАТЛАВ.  
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

### НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

**1.1 Аудитын нэр, код:** Онги-Ус суваг ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудит, ӨВА-2022/2/НА-СТА-ОНА

**1.2 Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:** Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 -д заасны дагуу санхүүгийн тайлангийн аудит хийнэ.

**1.3 Аудитын ажлын зорилго:** Онги-Ус суваг ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлж үнэн зөв толилуулсан эсэхэд санал дүгнэлт өгөхөд чиглэнэ.

**1.4 Аудитын ажлын шинж чанар, хугацаа, хамрах хүрээ:** Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай" 2021 оны А/87 дүгээр тушаалыг үндэслэн санал дүгнэлт гаргана.

Аудитыг ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар хэрэгжүүлж, аудитын тайланг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор шалгагдагч байгууллагын удирдлагад гардуулна.

Аудитад 2021 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, тодруулгууд, ерөнхий дэвтэр, ерөнхий журнал, анхан шатны баримт, үйл ажиллагааны тайлан болон бусад шаардлагатай баримтуудыг хамруулна.

Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлд тусгасан асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг тайлагнахаар энэхүү төлөвлөгөөнд тусгасан.

**1.5 Аудитын урьдчилсан үйл ажиллагааны үр дүн:** Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрөхүйц гэдгийг тодорхойлж, аудитын баг Төрийн аудитын байгууллагын Ёс зүйн дүрэмд заасан шаардлагууд болон үүрэг хариуцлагыг бүрэн ойлгож мэдэгдэл гаргасан бөгөөд ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдсэн болно.

Мөн аудитын ажлын захидлыг 2021 оны 12 дүгээр сарын 16-ны өдрийн 419 дугаар албан бичгээр шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж талуудын хүлээх үүрэг, хариуцлага болон аудитын урьдчилсан нөхцөлүүдийг харилцан тохиролцох, аудит хийх багийг танилцуулах нээлтийн уулзалтыг хянан удирдах ажилтнуудын оролцоотой гүйцэтгэж тэмдэглэл хөтөлсөн.

**1.6 Төлөвлөх үе шатанд хийсэн ажлууд, тэдгээрийн үнэлгээ:** Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам", 2021 оны А/70 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн тайлангийн

аудитын заавар, аргачлал"-ын дагуу аудитыг төлөвлөх үе шатны ажлыг бүрэн гүйцэтгэж, аудитын ажлын баримт бэлтгэж, хянуулсан.

### **1.6.1 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналтыг ойлгож эрсдэлтэй асуудлыг тодорхойлох:**

Онги-Ус суваг ОНӨААТҮГ нь 1936 онд нийтийн аж ахуйн үйлчилгээний чиглэлээр байгуулагдсан бөгөөд Арвайхээр, Сант суманд удирдах болон гүйцэтгэх нийт 70 ажилчид ажиллаж байна.

Ус хуримтлуулан ариутгаж түгээх үйл ажиллагааг эрхэлдэг. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс болон нийтийн аж ахуйн холбооноос Өмнөговь, Хэнтий, Хөвсгөл Булган аймгуудад шинээр баригдсан цэвэрлэх байгууламжыг ашиглалтанд оруулах зорилгоор туршилт, судалгааны ажлууд хийгдэж байгаа. Мөн шинээр 11 худгийг бүрэн автоматжуулсан

Байгууллагын үндсэн мэдээлэл, түүний гадаад орчин болон дотоод үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үйл явцыг судалж, ойлгосноор эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

Байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор бус нөхцөл байдалд тохирсон аудитын горимуудыг оновчтой төлөвлөхийн тулд аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголттой болсон. Дотоод хяналтын бүрэлдэхүүн хэсгийн талаар судалж эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын ажлыг аудитад ашиглахгүй гэж шийдвэрлэсэн.

### **1.6.2 Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг тодорхойлох:**

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалж, суурь үзүүлэлтийг 2021 оны жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн борлуулалтын орлогын дүнг сонгосон.

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлж, материаллаг байдлын түвшин 1 хувиар тогтоож, сонгосон суурь үзүүлэлтээс тооцож төлөвлөлтийн материаллаг байдлыг 65.7 сая төгрөгөөр тогтоож баримтжууллаа.

Дээрх ажлын баримтад материаллаг байдлын суурь үзүүлэлт, хувь хэмжээг сонгосон шалтгаан, тайлбар болон материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзэх шалтгаан, тайлбарыг тусгасан болно.

Мөн санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 49.3 сая төгрөгөөр тогтоолоо.

### **1.6.3 Эрсдэлийн үнэлгээний үр дүн:**

Байгууллага, түүний орчин, дотоод хяналтын талаар ойлголт авч, эрсдэлийн үнэлгээний горимыг үндэслэн санхүүгийн тайлангийн түвшинд, батламж мэдэгдлийн түвшинд уламжлалт болон хяналтын эрсдэлийг тодорхойлж, бүртгэсэн.

Тодорхойлсон эрсдэлүүдээс нөлөө бүхий эрсдэлийг эрэмбэлж, үнэлсэн бөгөөд холбогдох хяналт, түүний дотор хяналтын үйл ажиллагааг авч үзсэн.

Мөн ач холбогдолтой биш боловч материаллаг байж болзошгүй эрсдэлүүдийг бүртгэж шинж чанарын хувьд материаллаг эсэх, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлд нөлөөлөх эсэхийг үнэлсэн.

Эрсдэлийн үнэлгээнээс хамаарч нөлөө бүхий 5 эрсдэл тодорхойлж бие даасан горим болон хяналтын сорил хэрэгжүүлэхээр баримтжуулав.

**1.6.4 Үнэлсэн эрсдэлд өгөх ерөнхий хариу:** Үнэлсэн эрсдэлд өгөх ерөнхий хариуг зохиомжилж аудитыг гүйцэтгэх үе шатанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бие даасан горим болон хяналтын сорилд хамаарах батламж мэдэгдэл, стандартын болон хууль тогтоомжтой холбоотой шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх хугацааг тодорхойлов.

**1.6.5 Аудитын үр өгөөжийн урьдчилсан төлөвлөлт:** Санхүүгийн тайлангийн аудитаар 10.0 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж бий болгохоор урьдчилан тооцоолж, шалгагдагч байгууллагын үйл ажиллагаанд чанарын ахиц, дэвшил гарсныг санхүүгийн бус үр өгөөжөөр бүртгэхээр төлөвлөв.

**1.7 Санхүүгийн тайлангийн аудитад ашиглах нөөц:** Аудитад ашиглах нөөцийг дараах байдлаар тодорхойлов.

**1.7.1 Аудит хийх багийн бүрэлдэхүүн, гүйцэтгэх үүрэг:**

дд	Багийн гишүүдийн		Аудитын явцад гүйцэтгэх үүрэг
	Овог нэр	Албан тушаал	
1	Д.Гансүх	Аудитын менежер	Аудитын үе шатны хяналт хэрэгжүүлэх, арга зүйгээр хангах
2	Б.Эрдэнэцэцэг	Ахлах аудитор	Аудитыг гүйцэтгэх

**1.7.2 Аудитад зарцуулах хугацаа, төсөв:**

дд	Багийн гишүүдийн		Аудитад зарцуулах хугацаа (хүн/өдөр)	Аудитад зарцуулах төсөв (мян.төг)			
	Овог нэр	Албан тушаал		Цалин	Томилолт	Бусад	Дүн
	1	2	3	4	5	6	7
1	Д.Гансүх	Аудитын менежер	3	139.0			417.0
2	Б.Эрдэнэцэцэг	Ахлах аудитор	3	139.0		50.0	467.0
	<b>Дүн</b>		<b>6</b>	<b>139.0</b>		<b>50.0</b>	<b>884.0</b>

**ХОЁР. АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭХ ҮЕ ШАТАНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГОРИМ, СОРИЛ**

Хэрэгжүүлэх горим, сорилууд	Аудитын горимын		
	Шинж чанар	Хугацаа	Хамрах хүрээ
<b>2.1 Санхүүгийн тайлангийн түвшинд</b>			

1.	Шилэн дансны цахим системд мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулаагүй, хяналт тавиагүй байх	Мэргэжлийн үл үзлээр хандах	2022.03.07-2022.03.11	2021 оны Санхүүгийн тайлан, баримтууд
<b>2.2 Батламж мэдэгдлийн түвшинд</b>				
1	Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжүүлээгүй байх.	Бие даасан горим	2022.03.07-2022.03.11	2021 оны Санхүүгийн тайлан, баримтууд
2	Ковид 19 цар тахалтай холбоотой айл өрх, аж ахуйн нэгжид үзүүлсэн хөнгөлөлтийн орлогыг зориулалт бусаар зарцуулсан байх.	Бие даасан горим	2022.03.07-2022.03.11	2021 оны Санхүүгийн тайлан, баримтууд
3	Борлуулалтын орлогыг үнэн зөв тооцож тайлагнаагүй байх.	Бие даасан горим	2022.03.07-2022.03.11	2021 оны Санхүүгийн тайлан, баримтууд
4	Өглөг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байх.	Бие даасан горим	2022.03.07-2022.03.11	2021 оны Санхүүгийн тайлан, баримтууд
<b>2.3 Бусад төлөвлөсөн горимууд</b>				

**ГУРАВ. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ХӨТӨЛБӨР**

№	Хийгдэх ажил	Зарцуулах өдөр /тоогоор/	Эхлэх өдөр	Дуусах өдөр	Хариуцах ажилтны албан тушаал, овог, нэр
	1	2	3	4	5
1	Аудитын урьдчилсан үйл ажиллагаа	2	2021.12.23	2021.12.25	Ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг
2	Аудитыг төлөвлөх	1	2022.02.27	2022.02.28	Ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг
3	Аудитыг гүйцэтгэх	4	2022.03.07	2022.03.11	Ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг
4	Дуусгавар болох ба дахин хянах	1	2022.03.11	2022.03.12	Ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг
5	Аудитыг тайлагнах	2	2022.03.12	2022.03.15	Ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг
6	Аудитын дараах үйл ажиллагаа	84	2022.03.25	2022.04.25	Ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ:

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

/Д.ГАНСҮХ/

Огноо:

БОЛОВСРУУЛСАН:  
АХЛАХ АУДИТОР

/Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ/

Огноо: 2022.02.28

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Онги-Ус Суваг ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ӨВА-2022/2/НА-СТА-ОНА

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Арвайхээр сум  
2022 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com

Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг

Утас: 70323833 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	7
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	7
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	7
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	9
4. Аудитын тайлан.....	10
4.1 Ерөнхий зүйл.....	10
4.2 Дотоод хяналт.....	10
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
4.4 Материаллаг байдал.....	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	11
6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
8. Аудитын илрүүлэлт.....	12
8.1 Залруулсан алдаа.....	12
8.2 Төлбөрийн акт.....	12
8.3 Албан шаардлага.....	12
8.4 Зөвлөмж.....	12
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	0

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.Аудитын санал дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон П.Гэндэнгийн гудамж,  
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173  
Утас/Факс: (976) 7032 3253  
Цахим шуудан: ovorkhangai@audit.gov.mn,  
Цэжим хуудас: www.audit.mn

Аудит 03.15 № 320  
Танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ОНГИ-УС СУВАГ ОНӨААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ Ц.ХОРОЛСҮРЭН ТАНАА

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Онги-Ус суваг ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Онги-Ус суваг ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон зүйл

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар 6,570.3 сая төгрөгийн орлого хүлээн зөвшөөрч бүртгэсний 1,569.1 мянган төгрөг нь үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого, 5,001.2 сая төгрөг нь үнэ төлбөргүй авсан бараа материал, үндсэн хөрөнгийн орлого байна. Тайлант онд нийтийн эзэмшлийн бүртгэлд тусгаагүй байсан газар доогуурх шугамуудыг Аймгийн ИТХ-ын шийдвэрээр бүртгэлд тусгасан байна.

#### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

015030638

МУ-ын Засгийн газрын 211,207 дугаар тогтоолоор айл өрх, аж ахуй нэгжүүдийн усны төлбөрт 1,360.5 сая төгрөгийн хөнгөлөлтийг үзүүлэхээр тооцоо нийлж зөвшөөрөгдсөнөөс 1,178.4 сая төгрөгийн төлбөрийг ЗГ-аас төлж 182.1 сая төгрөгийн авлагаа нийлж баталгаажуулсан байна.

#### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

**2. Аудит хийсэн санхүүгийн тайлан****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>413,618.06</b>	<b>562,842.54</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>110,604.82</b>	<b>122,854.17</b>
<b>31100</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	<b>3,181.88</b>	<b>2,623.58</b>
31110	Төгрөг	3,181.88	2,623.58
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>107,422.94</b>	<b>120,230.59</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>107,422.94</b>	<b>120,230.59</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	107,422.94	120,230.59
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>148,672.87</b>	<b>251,959.88</b>
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0	517.19
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>148,672.87</b>	<b>251,442.69</b>
33510	Байгууллагаас авах авлага	148,469.76	251,391.59
33520	Хувь хүмүүсээс авах авлага	203.12	51.10
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>154,340.37</b>	<b>188,028.49</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>154,340.37</b>	<b>188,028.49</b>
35410	Бичиг хэргийн материал	11,117.12	10,236.06
35420	Аж ахуйн материал	22,099.57	30,624.58
35430	Сэлбэг хэрэгсэл	11,458.98	23,005.85
35470	Бусад хангамжийн материал	109,664.70	124,162.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,243,490.31</b>	<b>6,144,131.90</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,243,490.31</b>	<b>6,144,131.90</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,206,378.31</b>	<b>6,107,019.90</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	481,334.54	5,442,675.63
39202	Хуримтлагдсан элэгдэл	-25,916.35	-35,829.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	934,130.31	985,276.58
39204	Хуримтлагдсан элэгдэл	-393,268.14	-473,218.72
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	405,239.27	421,792.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	-207,145.03	-248,095.50
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,885.28	31,407.28
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,881.57	-16,988.54
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>37,112.00</b>	<b>37,112.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	37,112.00	37,112.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,657,108.36</b>	<b>6,706,974.44</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>70,360.95</b>	<b>39,392.69</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>70,360.95</b>	<b>39,392.69</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>70,360.95</b>	<b>39,392.69</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>70,360.95</b>	<b>39,392.69</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	0	239.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	17,015.38	39,153.69
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,586,747.41</b>	<b>6,667,581.80</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,586,747.41</b>	<b>6,667,581.80</b>
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,607,576.94	1,607,576.94
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-295,320.56</b>	<b>4,785,513.80</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-295,320.56	-295,320.56
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	5,080,834.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	274,491.03	274,491.03
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,657,108.36</b>	<b>6,706,974.40</b>

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,048,158.21</b>	<b>6,570,348.74</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,048,158.21</b>	<b>507.66</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,048,158.21</b>	<b>507.66</b>
120002	Хүүгийн орлого	0	241.06
120003	Торгуулийн орлого	0	266.60
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,048,158.21</b>	<b>6,569,841.08</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	867,951.35	1,370,840.27
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	180,206.87	197,805.72
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0	5,001,195.09
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,307,210.45</b>	<b>1,477,614.39</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,307,210.45</b>	<b>1,477,614.39</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,278,096.56</b>	<b>1,447,928.60</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>566,030.39</b>	<b>656,478.39</b>
210101	Үндсэн цалин	534,491.79	656,478.39
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>84,001.47</b>	<b>90,955.66</b>
210201	Тэтгэврийн даатгал	59,112.15	90,955.66
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>148,860.25</b>	<b>216,588.80</b>
210301	Гэрэл, цахилгаан	133,911.76	197,524.71
210302	Түлш, халаалт	12,867.25	19,064.09
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>58,349.29</b>	<b>168,077.14</b>
210401	Бичиг хэрэг	2,390.52	5,183.05
210402	Тээвэр, шатахуун	52,480.31	76,627.44
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,478.46	12,144.70
210404	Ном, хэвлэл	0	230.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0	3,412.75
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0	6,237.38
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0	46,505.73
210408	Сэлбэг хэрэгслийн	0	17,736.08
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>15,164.66</b>	<b>10,384.43</b>
210502	Хоол, хүнс	0	10,384.43
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>22,203.63</b>	<b>86,496.52</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0	18,933.29
210604	Урсгал засвар	22,203.63	67,563.23
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,566.60</b>	<b>779.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,566.60	779.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>152,283.00</b>	<b>73,049.32</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,600.00	28,845.25
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500.00	2,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	220.00	279.29
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0	231.00
210807	Газрын төлбөр	0	24,802.28
210813	Бусад зардал /ТӨҮГ/	126,689.24	7,942.69
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	0	8,848.81
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>229,637.27</b>	<b>145,119.35</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	136,855.37	145,119.35
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>29,113.89</b>	<b>29,685.79</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>29,113.89</b>	<b>29,685.79</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	10,146.29
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,113.89	19,539.50
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-259,052.24</b>	<b>5,092,734.35</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0</b>	<b>11,900.00</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	11,900.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-259,052.24</b>	<b>5,080,834.35</b>

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,536,326.94	274,491.03	-36,268.32	1,774,549.65
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,536,326.94	274,491.03	-36,268.32	1,774,549.65
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	71,250.00	0	0	71,250.00
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-259,052.24	-259,052.24
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,607,576.94	274,491.03	-295,320.56	1,586,747.41
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,607,576.94	274,491.03	-295,320.56	1,586,747.41
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,607,576.94	274,491.03	-295,320.56	1,586,747.41
19	Тайлант үеийн үр дүн	0	0	5.08	5.08
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,607,576.94	274,491.03	-295,315.48	1,586,752.49

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,219,521.18</b>	<b>1,657,408.65</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,219,521.18</b>	<b>507.66</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,219,521.18</b>	<b>507.66</b>
120002	Хүүгийн орлого	0	241.06
120003	Торгуулийн орлого	0	266.60
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,219,521.18</b>	<b>1,656,900.99</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	869,784.61	1,370,840.27
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	349,736.57	240,865.76
120009	Бусад орлого	0	45,194.96
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,251,906.89</b>	<b>1,568,804.30</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,251,906.89</b>	<b>1,568,804.30</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,251,906.89</b>	<b>1,539,717.50</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>485,676.42</b>	<b>647,290.24</b>
210101	Үндсэн цалин	454,137.82	616,843.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,838.60	24,759.94
210104	Урамшуулал/түлээний хөнгөлөлт/	4,700.00	5,687.01
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>84,001.47</b>	<b>90,955.66</b>
210201	Тэтгэврийн даатгал	59,112.15	90,955.66
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>146,779.01</b>	<b>216,588.80</b>
210301	Гэрэл, цахилгаан	133,911.76	197,524.71
210302	Түлш, халаалт	12,867.25	19,064.09
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>138,536.76</b>	<b>204,096.56</b>
210401	Бичиг хэрэг	2,390.52	3,536.15
210402	Тээвэр, шатахуун	52,480.31	76,206.74
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,478.46	12,144.70
210404	Ном, хэвлэл	0	230.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0	3,412.75
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0	3,786.50
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	13,853.58	24,552.20
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	66,333.89	80,227.52
2105	<b>Нормативт зардал</b>	<b>0</b>	<b>21,933.33</b>

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0	2,093.30
210502	Хоол, хүнс	0	10,384.43
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0	9,455.60
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>37,368.29</b>	<b>92,382.95</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	15,164.66	16,772.28
210604	Урсгал засвар	22,203.63	75,610.68
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,566.60</b>	<b>779.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,566.60	779.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>357,978.35</b>	<b>265,690.97</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	28,845.25
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500.00	2,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0	279.29
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	220.00	231.00
210807	Газрын төлбөр	295.20	24,802.28
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	96,025.67	68,797.19
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	257,663.72	140,635.95
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>0</b>	<b>29,086.79</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0</b>	<b>29,086.79</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	9,547.29
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	19,539.50
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>-32,385.71</b>	<b>88,604.35</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>35,254.50</b>	<b>76,355.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>35,254.50</b>	<b>76,355.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>35,254.50</b>	<b>76,355.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	35,254.50	76,355.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-35,254.50</b>	<b>-76,355.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-67,640.21</b>	<b>-110,481.96</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	178,245.03	110,604.82
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	110,604.82	122.85

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Онги-Ус суваг ОНӨААТҮГ нь “Чанартай үйлчилгээгээрээ танигдаж хөгжилд тэмүүлсэн манлайлагч байгууллага болно”. гэж алсын хараагаа тодорхойлсон.

“Хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан цэвэр усаар хангах, экологийн үнэлэмжид нийцүүлэн ариутгах татуургын үйлчилгээг үзүүлэх, төвийн халаалтыг горимын дагуу тасралтгүй дамжуулах үйлчилгээг найдвартай хангаж ажиллахад оршино” гэсэн эрхэм зорилго дэвшүүлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд 100 хувийн орон нутгийн өмчит статустай байна.

#### 3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Онги ус суваг” ОНӨААТҮГ нь

1936-1957 онд “Гар үйлдвэрийн артель”

1957-1971 онд “Нийгэм хангамжийн төв”

1971-1990 онд “Нийтийн аж ахуйн газар”

1990-1991 онд “Орон сууц нийтийн аж ахуйн газар”

1991-1998 онд “Чандмань эрдэнэ”  
 1998-2004 онд “Нийтийн аж ахуй үйлчилгээний газар”  
 2004 оноос “Онги ус суваг” нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн.

Онги ус суваг ОНӨААТҮГ нь Иргэний хууль, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Хот суурины усан хангамж ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Усны тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хүрээнд Арвайхээр хотын хэмжээнд дараах үйлдвэрлэл үйлчилгээг эрхлэн явуулна гэж заасан байна.

1. Хүн ам ААНБ, үйлдвэр үйлчилгээний газрыг стандартын шаардлага хангасан цэвэр усаар байнга тасралтгүй хангана.
2. Хүн ам ААНБ-н хэрэгцээнээс гарсан бохир усыг зайлуулж зохих стандартын дагуу цэвэрлэнэ.
3. Төвлөрсөн халаалтын зуухны дулааныг өөрийн эзэмшлийн шугам сүлжээгээр дамжуулна.
4. Цэвэр усны алдагдлыг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх цэвэр бохир усанд стандартын шаардлагын дагуу лабораторийн шинжилгээ хийнэ.
5. Орон сууцны айл өрх, СӨХ, ААНБ, иргэдийн хүсэлтээр цэвэр, бохир усны шугам сүлжээний засвар үйлчилгээний ажлыг төлбөртэйгөөр хийх, ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулна.
6. Өөрийн эзэмшлийн ус хангамж, ариутгах татуурга, дулааны барилга байгууламж, шугам, сүлжээ, техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд шинэчлэлт хийх, шинэ техник, технологи нэвтрүүлэх, үйлдвэрлэл үйлчилгээний чанарыг сайжруулах, нэр төрлийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохих журмын дагуу хэрэгжүүлнэ.
7. Эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр дулааны үйлдвэрлэл хангамж, бетон ба төмөр эдлэлийн үйлдвэрлэл худалдаа, цэвэр усны шугам сүлжээ, барилга угсралт, засварын ажлыг гүйцэтгэнэ.
8. Усны тоолуурын туршилт тохируулгын ажил гүйцэтгэх.
9. Барилга байгууламжийг цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээнд холбох, ус түгээх байр барихад хот байгуулалтын төлөвлөгөөнд нийцүүлэн техникийн нөхцөл олгож ажлын явцад мэргэжлийн зөвлөгөө өгч хяналт тавина.

гэж заасан байна.

Анх 2005-01-28 ны өдрийн №14-р тогтоолоор 5 хүний бүрэлдэхүүнтэй ТУЗ байгуулагдсан. Үүнээс хойш 2010, 2014, 2017, 2020 онуудад ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 4 удаа өөрчилсөн. Хамгийн сүүлд 2020-12-15-ны өдрийн №77 тоот тогтоолоор 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр ТУЗ-ийг баталж үйл ажиллагаагаа явуулж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 9 хүний бүрэлдэхүүнтэй томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дэх заалттай нийцэж байна.

Өвөрхангай аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Аймгийн засаг даргын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.5.1.2-т “Зарим сумдын төвийн цэвэр усны болон ариутгах татуургын нэгдсэн байгууламж, дулааны төвлөрсөн системийг бий болгон, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага айл өрхүүдийг холбогдох нөхцөлийг бүрдүүлж,” Сумын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлнэ.” гэж заасан байна. Энэ хүрээнд тайлант онд Хайрхандулаан суманд ОНХО-аар цэвэрлэх байгууламжийг барьж, сумын төсвийн байгууллага, айл өрхүүдийг цэвэр бохирын шугамд холбож ашиглалтад оруулсан байна. Онги-Ус суваг компани үйл ажиллагааг нь хариуцаж ажиллахаар гэрээ байгуулжээ.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ

г.м)-ын зардлыг гаргахгүй байх;"-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй, чиг үүргийн давхардлыг арилгаж, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоосон байна. Шагнал урамшуулал олгосон, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардал гаргасан зөрчил илрээгүй болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйл

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Онги-Ус суваг ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	110,604.8	122,854.2	12,249.4
БХХО			
Авлага	148,672.9	251,959.9	103,287.0
Урьдчилгаа			
Бараа материал	154,340.4	188,028.5	33,688.1
Үндсэн хөрөнгө	1,243,490.3	6,144,131.9	4,900,641.6
Биет бус хөрөнгө			
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,657,108.4</b>	<b>6,706,974.4</b>	<b>5,049,866.0</b>
Өр төлбөрийн дүн			
Богино хугацаат өглөг	70,360.9	39,392.7	-30,968.2
Урт хугацаат өглөг			
Эздийн өмч	1,586,747.4	6,667,581.8	5,080,834.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,657,108.4</b>	<b>6,706,974.4</b>	<b>5,049,866.0</b>

Банк дахь мөнгөний үлдэгдэл 122.8 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэл өмнөх оноос 103.3 сая төгрөгөөр өссөн байгаа нь Засгийн газраас авах хөнгөлөлтийн авлагын 182.1 сая төгрөг нол нөлөө үзүүлжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 188.0 сая төгрөг болж 33.7 сая төгрөгөөр өссөн нь 11.5 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 14.5 сая төгрөгийн бусад хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд худалдан авалтаар 55.3 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 16.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 4.5 сая төгрөгийн тавилга эд хогшил нэмэгдсэн байна.

Үнэ төлбөргүйгээр 4 тэрбум 991.3 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэний 4 тэрбум 961.3 сая төгрөг нь барилга байгууламж, 29.9 сая төгрөг нь авто машин байна.

Үндсэн хөрөнгийн данснаас 34.1 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 6 тэрбум 918.3 сая төгрөгийн хөрөнгүүдийг нь өөрөө бүрэн ашиглаж байгаа нь санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг хангаж байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 39.4 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 33.7 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй гарчээ. Өмнөх оны байгууллагад төлөх 53.3 сая төгрөгийн өрийг бүрэн төлж дуусгасан ч тайлант онд 39.1 сая төгрөгийн татварын өртэй гарчээ.

### **3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу "байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй".

ТУЗ-ийн 2021 оны 3 дугаар тогтоолоор Онги-Ус суваг ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогын эх үүсвэрийг 1 тэрбум 381.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 1 тэрбум 379.7 сая төгрөгөөр баталж 1.8 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөжээ. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 145.2 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1 тэрбум 426.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1 тэрбум 336.5 сая төгрөгийн зардал гарган, 89.5 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. /Татварын тайлангаар/

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 76.3 сая төгрөгийн худалдан авалт хийж, хөрөнгө оруулалтын зардлыг 47.5 хувиар хэмнэсэн байна.

## **4. Аудитын тайлан**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Онги-Ус суваг ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад Шилэн дансны тухай хуультай холбоотой өгсөн 1 зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Онги-Ус суваг ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 25 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Дотоод хяналт**

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Онги-Ус суваг ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт борлуулалтын орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 6 тэрбум 570.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 65.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 18 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь тайлант онд нийт 1 тэрбум 426.0 сая төгрөгийн 148 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 146 мэдээллийг байршуулсан байна. 1 мэдээллийн хугацаа болоогүй, Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлээгүй, 26 мэдээллийг хугацаа хоцроосон байгаад зөвлөмж хүргүүлсэн болно.

#### 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

### 6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 8.7 сая төгрөгийн авлагыг барагдуулах тухай өгсөн албан шаардлагаас 2021 онд 2.0 сая төгрөгийг барагдуулаад үлдсэн 6.7 сая төгрөгийн авлага одоог хүртэл барагдаагүй байна. Учир шалтгааныг тодруулбал: “авлагын эзэн холбогдогч нь ажлаасаа гарсан, нэхэмжлээд төлөхгүй байгаа тул холбогдох материалыг бүрдүүлж шүүхэд хандах талаар яригдаж байгаа” гэсэн тайлбар өгсөн тул албан шаардлагын үлдэгдлийг энэхүү тайлангийн Хүснэгт 3-т харуулав.

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар 19.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн байна. Биелэлтийг 2021 оны 06.04-ний өдрийн 98 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага/2019	1	6.7			1	6.7	
Албан шаардлага/2020	1	19.9	1	19.9			100
Дүн	2	26.6	1	19.9	1	6.7	

### 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын гүйцэтгэх захирлын шийдвэрээр олгосон цалингийн нэмэгдэл, урамшуулалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх цаг хугацааны боломж гараагүй тул дараагийн аудитаар анхаарах болно.

### 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

#### 8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд залруулга гараагүй.

#### 8.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

#### 8.3 Албан шаардлага

1. Нийт авлагаас 5.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

#### 8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх талаар

###### Илрүүлэлт:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 148 мэдээллийг ил тод байршуулахаас 146 мэдээллийг байршуулсан байна. 1 мэдээллийн хугацаа болоогүй байна. "Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг" мэдээлээгүй, 26 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

###### Өгсөн зөвлөмж:

Зөвлөмж-1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, ажлын хариуцлагыг сайжруулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад **2022 оны 05 дүгээр сарын 25-ны** өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Үүнээс		Хариуцлага тооцох	Зөвлөмж
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Онги-Ус суваг ОНӨААТҮГ	ӨВА-2022/2/НА-СТА-ОНА	Нийт авлагаас 5624.4 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх.	1	5624.4	1	5624.4						
<b>ДҮН</b>					1	5624.4	1	5624.4						
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал														
1	Онги-Ус суваг ОНӨААТҮГ	ӨВА-2022/2/НА-СТА-ОНА	148 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 146 мэдээллийг байршуулсан байна. 1 мэдээллийн хугацаа болоогүй байна. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлээгүй, 26 мэдээллийг хугацаа хоцроосон байна.	Зөвлөмж- Шилэн дансны 1.Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, ажлын хариуцлагыг сайжруулж ажиллах.	1									1
<b>ДҮН</b>					2	5624.4								
<b>НИЙТ ДҮН</b>							1	5624.4						1



АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАГАН  
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ  
 АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ  
 БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 18 өдөр

Дугаар НА-2022/2/НА-ЦА-ОНА/А/550349/2022 Арвайхээр

ОНГИ-УС СУВАГ ОНӨААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ Ц.ХОРОЛСҮРЭН ТАНАА  
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 5624.4 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.7-д заасан "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Дээр дурдсан зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан тухай биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Онги-Ус суваг ОНӨААТҮГ-ын захирал Ц.Хоролсүрэн, нягтлан бодогч С.Оюундолгор нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

АХЛАХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

